



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

ЖК оны 07 сарын 08 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

### Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Цэцэнс майнинг энд энержи” ХХК-тай байгуулсан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний дагуу төрийн өмчид шилжүүлсэн, нийт 41,316,659,700.00 (дөчин нэгэн тэрбум гурван зуун арван зургаан сая зургаан зуун тавин есөн мянга долоон зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001200

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 07 дугаар сарын .....-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэх  
хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)
1	220кВ-ын 2 хэлхээт Багануур- Бөөрөлжүүтийн Цахилгаан дамжуулах агаарын шугам	2025	км	71.8	575,440,942.90	41,316,659,700.00
	Нийт дүн				575,440,942.90	41,316,659,700.00
					(таван зуун далан таван сая дервөн зуун дечин мянга есөн зуун дечин хоёр төгрөг ерэн мөнгө)	(дечин нэгэн тэрбум гурван зуун арван зургаан сая зургаан зуун тавин есөн мянга долоон зуу)